



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 04

Мөрөн

Газар зохион байгуулалтын 2020 оны  
төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.2.3 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд төсөвт байгууллагад зайлшгүй эзэмшүүлэх газрыг тодотгон хавсралтаар баталсугай.

2. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын тодотгол төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд), аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганзориг) нарт даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

119120020

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус  
XII хуралдааны 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн  
04 дүгээр тогтоолын хавсралт



Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны тухайн  
жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол

Үндэслэл

1. Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт / 21.3.2. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна./

2. ГЗБГЗЗГын даргын 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 497 тоот тушаалаар баталсан “ Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”

3. 2015 онд батлагдсан Хөвсгөл аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Мөрөн сумын хэтийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

4. ГЗБГЗЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 1/614 тоот албан бичиг зэргийг үндэслэн боловсрууллаа.

**Төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын төлөвлөлт**

№	Байршил	Талбайн хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Хариуцах эзэн
1	Мөрөн сум 7-р баг аюулгүйн тойргийн урд талд	0.4	Албан хэрэгцээнд	2-р улиралд		ГХБХБГ
Дүн		0.4				

